


ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/556

Алтай хот

┌ Хилийн 0214 дүгээр ангид дэмжлэг ┐
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, 4.1 дэх хэсэг, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 39 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хилийн бүсийн дэглэмийг сахиулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн бүсийг тэмдэгжүүлэх ажилд 2,088,170 (хоёр сая наян найман мянга нэг зуун дал) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх дэмжлэгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Тэмдэгжүүлэлтийн ажлыг тогтоосон цэгүүдэд хийж, тайлагнан ажиллахыг Хилийн 0214 дүгээр анги (В.Батжаргал)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Ц.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР